ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Уламжлалт анагаах ухааны төвийн  2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2022/117/СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улиастай сум<br>2022 он | Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Үндраа<br>Утас: 99993365<br>Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn<br><br>Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч : Г.Заяа<br>Утас:92038288<br>Цахим хаяг:zayag@audit.gov.mn<br><br>Аудитор:Ц.Алтантуул<br>Утас: 91195554<br>Цахим хаяг : tuul9565@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........................................4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........................................5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........................................6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........................................9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан........................................10
3. Аудитын тайлан........................................11
3.1 Ерөнхий зүйл ........................................11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........................................11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........................................11
3.4 Материаллаг байдал ........................................12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........................................12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв........................................13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........................................13
3.8 Аудитын гол асуудал ........................................13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........................................13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт........................................13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт........................................14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал........................................14
4. Аудитын илрүүлэлт ........................................14
4.1 Залруулсан алдаа........................................14
4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй ........................................14
4.3 Албан шаардлага ........................................14
4.4 Зөвлөмж ........................................14


## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

2022. 02. 22 № 1302/128

танай ________________-ны №____________________-т

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ТӨВИЙН ДАРГА Д.ӨЛЗИЙБАЯР-д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Уламжлалт анагаах ухааны төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

*8,689.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг холбогдох байгууллагын шийдвэргүйгээр бэлтгэсэн, 2,875.0 мянган төгрөгийн зардлын анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй зөрчил нь* ( Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 77.3, Төсвийн тухай хуулийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй) *байна.*

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

013022037

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **41,860,678.11** | **320,266,678.37** |
| **33** | **АВЛАГА** | 731,483.63 | 168,964,363.89 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 731,483.63 | 1,013,129.29 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 00.00 | 167,788,624.60 |
| **335** | **Бусад авлага** | 00.00 | 162,610.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 162,610.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 41,129,194.48 | 151,302,314.48 |
| **351** | **Түүхий эд материал** | 28,610,654.45 | 37,776,145.45 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 12,657,744.45 | 12,657,744.45 |
| 35130 | Эм боох материал | 15,952,910.00 | 25,118,401.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 12,518,540.03 | 113,526,169.03 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 285,500.00 | 973,800.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 9,979,700.00 | 44,192,100.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 00.00 | 78,729.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 866,000.00 | 56,032,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 948,200.03 | 11,810,400.03 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 439,140.00 | 439,140.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **521,649,763.72** | **549,899,059.83** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 521,649,763.72 | 549,899,059.83 |
| **392** | **Биет хөрөнгө** | 521,649,763.72 | 528,886,059.83 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 500,000,000.00 | 500,000,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -13,888,888.92 | -27,777,777.84 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 5,337,499.83 | 5,337,499.83 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -2,891,145.66 | -3,780,728.94 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 74,916,861.58 | 94,883,861.58 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -54,711,296.84 | -63,632,761.80 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 24,335,591.18 | 38,939,391.18 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -11,448,857.45 | -15,083,424.18 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 950,000.00 | 950,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -950,000.00 | -950,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 00.00 | 21,013,000.00 |
| 39301 | Програм хангамж | 462,000.00 | 7,462,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -462,000.00 | -462,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 00.00 | 14,013,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **563,510,441.83** | **870,165,738.20** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **167,948,624.60** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 167,948,624.60 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 167,948,624.60 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 167,948,624.60 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 133,658,624.60 |

| | | | |
|---|---|---|---|
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 00.00 | 34,290,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **563,510,441.83** | **702,217,113.60** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 563,510,441.83 | 702,217,113.60 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 38,528,504.54 | 52,541,504.54 |
| 51101 | Өмч: - төрийн | 38,528,504.54 | 52,541,504.54 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 524,149,192.49 | 648,842,864.26 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 524,149,192.49 | 524,149,192.49 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 124,693,671.77 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 832,744.80 | 832,744.80 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **563,510,441.83** | **870,165,738.20** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **422,229,600.00** | **795,735,812.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **24,352,700.00** | **19,924,676.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 18,852,700.00 | 19,924,676.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 18,852,700.00 | 19,924,676.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 17,872,100.00 | 8,993,976.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 360,000.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 620,600.00 | 10,930,700.00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 5,500,000.00 | 00.00 |
| 123002 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 5,500,000.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **397,876,900.00** | **775,811,136.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 165,122,700.00 | 40,172,780.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 165,122,700.00 | 40,172,780.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 00.00 | 26,700,000.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 26,700,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 232,754,200.00 | 708,938,356.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 00.00 | 278,540,000.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 232,754,200.00 | 430,398,356.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **437,960,901.94** | **671,042,140.23** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **437,960,901.94** | **671,042,140.23** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 437,240,901.94 | 644,342,140.23 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 245,200,044.60 | 313,149,856.00 |
| 210101 | Үндсэн цалин | 186,424,881.60 | 153,421,926.00 |
| 210102 | Нэмэгдэл | 29,298,261.00 | 137,835,776.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,756,600.00 | 12,330,000.00 |
| 210104 | Урамшуулал | 16,720,302.00 | 9,562,154.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 31,530,349.24 | 41,033,401.34 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,877,303.59 | 28,669,987.35 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,573,800.25 | 3,131,498.56 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,971,680.40 | 2,505,198.84 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 464,323.91 | 601,813.27 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,643,241.09 | 6,124,903.32 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 57,360,227.30 | 75,684,293.94 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,424,277.30 | 7,461,073.94 |
| 210302 | Түлш, халаалт | 37,307,500.00 | 59,668,300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 12,628,450.00 | 8,554,920.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12,283,917.00 | 16,898,467.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,733,600.00 | 2,960,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 777,317.00 | 1,776,542.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 628,200.00 | 1,084,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,445,400.00 | 1,995,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,699,400.00 | 9,081,525.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 58,364,697.96 | 148,234,568.06 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 25,611,717.00 | 112,415,958.06 |
| 210502 | Хоол, хүнс | 32,752,980.96 | 35,818,610.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,143,466.00 | 7,940,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 801,000.00 | 1,413,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,342,466.00 | 6,526,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 935,900.00 | 14,067,050.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 13,188,020.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 395,900.00 | 738,900.00 |
| 210807 | Газрын төлбөр | 00.00 | 140,130.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 29,422,299.84 | 27,334,503.89 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 29,422,299.84 | 27,334,503.89 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 720,000.00 | 26,700,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 360,000.00 | 26,700,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 360,000.00 | 26,700,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 360,000.00 | 00.00 |
| 213302 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө | 360,000.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-15,731,301.94** | **124,693,671.77** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-15,731,301.94** | **124,693,671.77** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 38,528,504.54 | 1,438,253.00 | 14,210,529.18 | 54,177,286.72 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **38,528,504.54** | **1,438,253.00** | **14,210,529.18** | 54,177,286.72 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 525,427,771.63 | 525,427,771.63 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **38,528,504.54** | **832,744.80** | **524,149,192.49** | 563,510,441.83 |
| D01 | **2021 оны 01-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **38,528,504.54** | **832,744.80** | **524,149,192.49** | 563,510,441.83 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **38,528,504.54** | **832,744.80** | **524,149,192.49** | 563,510,441.83 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 14,013,000.00 | 00.00 | 00.00 | 14,013,000.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 124,693,671.77 | 124,693,671.77 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **52,541,504.54** | **832,744.80** | **648,842,864.26** | 702,217,113.60 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **421,609,000.00** | **617,016,487.40** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **23,732,100.00** | **8,993,976.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 18,232,100.00 | 8,993,976.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 18,232,100.00 | 8,993,976.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 17,872,100.00 | 8,993,976.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **397,876,900.00** | **608,022,511.40** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 165,122,700.00 | 40,172,780.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 165,122,700.00 | 40,172,780.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 00.00 | 26,700,000.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 26,700,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 232,754,200.00 | 541,149,731.40 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 00.00 | 278,540,000.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 232,754,200.00 | 262,609,731.40 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **420,759,000.00** | **606,611,687.40** |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **420,759,000.00** | **606,611,687.40** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **420,399,000.00** | **579,911,687.40** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 242,955,213.67 | 311,647,401.00 |
| 210101 | Үндсэн цалин | 133,208,663.12 | 146,065,097.00 |
| 210102 | Нэмэгдэл | 77,481,482.00 | 136,020,859.51 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,368,990.00 | 12,302,687.82 |
| 210104 | Урамшуулал | 19,896,078.55 | 17,258,756.67 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 33,370,200.00 | 42,817,502.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,482,700.00 | 31,264,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,471,900.00 | 2,852,602.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,977,500.00 | 2,319,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 494,400.00 | 580,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,943,700.00 | 5,800,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 57,360,227.30 | 51,804,293.94 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,424,277.30 | 7,461,073.94 |
| 210302 | Түлш, халаалт | 37,307,500.00 | 35,788,300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 12,628,450.00 | 8,554,920.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,385,617.00 | 24,626,706.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,187,500.00 | 3,249,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 777,317.00 | 2,017,881.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 628,200.00 | 1,084,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,645,400.00 | 1,995,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,147,200.00 | 16,280,125.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 71,863,076.03 | 133,092,654.46 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 35,449,172.00 | 93,708,944.46 |
| 210502 | Хоол, хүнс | 32,698,404.03 | 37,766,710.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,715,500.00 | 1,617,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,032,166.00 | 11,513,900.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,142,700.00 | 4,961,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,339,466.00 | 6,552,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,432,500.00 | 4,409,230.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 3,530,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 249,300.00 | 738,900.00 |
| 210807 | Газрын төлбөр | 00.00 | 140,130.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **360,000.00** | **26,700,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 360,000.00 | 26,700,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 360,000.00 | 26,700,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **850,000.00** | **10,404,800.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **850,000.00** | **10,404,800.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **850,000.00** | **10,404,800.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 850,000.00 | 10,404,800.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 850,000.00 | 10,404,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-850,000.00** | **-10,404,800.00** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 759,095,936.00 | 586,786,287.40 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 759,095,936.00 | 586,786,287.40 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 759,095,936.00 | 586,786,287.40 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 311,647,401.00 | 311,647,401.00 |
| 210101 | Үндсэн цалин | 167,376,532.00 | 146,065,097.00 |
| 210102 | Нэмэгдэл | 107,535,343.18 | 136,020,859.51 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 14,188,425.82 | 12,302,687.82 |
| 210104 | Урамшуулал | 22,547,100.00 | 17,258,756.67 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 42,817,502.00 | 42,817,502.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,248,702.00 | 31,264,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,642,200.00 | 2,852,602.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,113,800.00 | 2,319,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 528,400.00 | 580,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,284,400.00 | 5,800,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 75,684,293.94 | 51,804,293.94 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,461,073.94 | 7,461,073.94 |
| 210302 | Түлш, халаалт | 59,668,300.00 | 35,788,300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,554,920.00 | 8,554,920.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 25,026,630.00 | 24,626,706.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,649,000.00 | 3,249,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,017,881.00 | 2,017,881.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,084,500.00 | 1,084,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,995,200.00 | 1,995,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 16,280,049.00 | 16,280,125.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 183,504,259.06 | 133,092,654.46 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 121,581,449.06 | 93,708,944.46 |
| 210502 | Хоол, хүнс | 46,680,810.00 | 37,766,710.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 15,242,000.00 | 1,617,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 99,508,800.00 | 21,918,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 32,854,900.00 | 10,404,800.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 4,961,000.00 | 4,961,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 61,692,900.00 | 6,552,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 20,907,050.00 | 879,030.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 738,900.00 | 738,900.00 |
| 210807 | Газрын төлбөр | 140,130.00 | 140,130.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 759,095,936.00 | 311,776,487.40 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 40,172,780.00 | 40,172,780.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 40,172,780.00 | 40,172,780.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 708,938,356.00 | 262,609,731.40 |
| 134003 | Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт | 708,938,356.00 | 262,609,731.40 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 9,984,800.00 | 8,993,976.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,984,800.00 | 8,993,976.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 18.00 | 19.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 11.00 | 12.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 06.00 | 06.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **26,700,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **26,700,000.00** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 26700000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 26,700,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 26,700,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Уламжлалт анагаах ухааны төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл,тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интер аудит ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул, Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр нар гүйцэтгэж, хяналтыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.
Уламжлалт анагаах ухааны төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Уламжлалт анагаах ухааны төв нь тухайн хүнийхээ бие махбодыг бүхэл цогц үзлийн үүднээс нэгдмэл байдлаар авч үзэн хүч тамир дархлааг сэргээж хий цусны гүйдлийг тэнцвэржүүлж өгдөг. Өвчин үүсгэгч гол хүчин зүйл болох сэтгэл засал, хоол эмчилгээ, хөдөлгөөн засал эмчилгээг цаг улиралтай нь уялдуулан эмчилж, үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээ сэтгэлд нийцсэн тусламж үйлчилгээг үзүүлэх зорилго тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Уламжлалт анагаах ухааны төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 661.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 9.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| АВЛАГА | 731.48 | 168,964.36 | (168,232.88) |
| БАРАА МАТЕРИАЛ | 41,129.19 | 151,302.31 | (110,173.12) |
| ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 521,649.76 | 549,899.06 | (28,249.30) |
| БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 167,948.62 | (167,948.62) |
| Засгийн газрын хувь оролцоо | 563,529.01 | 702,235.68 | (138,706.67) |
| ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 563,529.01 | 870,184.30 | (306,655.30) |

Авлага дансны үлдэгдэл 168,232.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд ковидтой холбоотой эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлагын тооцоо үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын данс 110,173.1 мянган төгрөгөөр өссөн нь цаг үеийн шаардлагаар эм боох материалын нөөц үүссэн, тухайн жилд хийх ёстой урсгал засвар дэлгэмэл эмнэлэг болж ажилласантай холбоотойгоор хугацаа хойшилсон зэрэгтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 28,249.3 мянган төгрөгөөр өссөн нь газар орлого авсан болон хөрөнгө бэлтгэсэнтэй холбоотой .

Өр төлбөр дансны үлдэгдэл 167,948.6 мянган төгрөгөөр өссөн нь эрүүл мэндийн даатгалын санхүүжилт хугацаандаа төвлөрөөгүйгээс шалтгаалан эм нэг удаагийн хэрэгсэл болон бусад хөрөнгийг зээлэр худалдан авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 138,706.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 581,322.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 581,322.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 40,172.7 мянган төгрөгийн, эрүүл мэндийн даатгалын сангаас 262,609.7 мянган төгрөгийн, нийгмийн даатгалын сангаас 278,540.0 мянган төгрөгийн, өөрийн эх үүсвэрээс 8,993.9 мянган төгрөгийн нийт 590,316.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 590,316.3 мянган төгрөгийг зарцуулсан байна. Тайлант онд ковидын эмчилгээг хийдэг болсноор санхүүжилт батлагдсан төсвөөс өссөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант ковидтой холбоотой дээд шатны байгууллагаас 26,700.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийг орлогыг бүрдүүлсэн.

Нэмэлт орлогоос ковидтой холбоотой албан хаагчдын тэтгэмжид 26,700.0 мянган төгрөгийг шийдвэрийн дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант онд холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр хөрөнгө бэлтгэсэн, зарим зардлын анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллаагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 102 мэдээлэл, хугацаа хоцроосон 47 мэдээлэл байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэхэд шилэн дансанд мэдээлэл байршуулахдаа хугацаа хоцроосон байгаад анхаарч ажиллах шаардлагатай байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагад ашиглагдаж байгаа хөрөнгийн бүртгэлд тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 42,052.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 30,487.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 8,689.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 2,875.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

- Газар бүртгэлд авахдаа 10,899.0 мянган төгрөгийн зөрүүтэй дүнгээр тусгасныг залруулсан;
- Бараа материалд 13,261.6 мянган төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгийн шинжтэй зүйлсийг тусгасныг залруулсан;
- Эм боох материалын үлдэгдлийг 6,327.1 мянган төгрөгийн зөрүүтэй тусгасныг залруулсан;

### 4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй

### 4.3 Албан шаардлага

Холбогдох байгууллагын зөвшөөрөлгүй 8,689.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө олж бэлтгэсэн тул албан шаардлага хүргүүлэв.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

- ✓ *2,875.0 мянган төгрөгийн зардлын и баримтгүй гүйлгээг бүртгэж тайлагнасан.*

*1.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

- ✓ *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт*

*үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ."; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ."; гэж заасныг хэрэгжүүлж ажиллах*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1. | Уламжлалт анагаах ухааны төв | 5 | 42,052.3 | 3 | 30,487.7 | | | 1 | 8,689.6 | 1 | 2,875.0 |
| | **Нийт дүн** | **5** | **42,052.3** | **3** | **30,487.7** | | | **1** | **8,689.6** | **1** | **2,875.0** |